ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2017.06.23

№	Ажлын чиглэл	Хийгдсэн ажлууд
1.	Тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	-Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн амбулаторийн тусламж үйлчилгээний хүлээгдэл чирэгдлийг бууруулах зорилгоор 1 сарын аян зохион байгуулж аяны хүрээнд удирдлагын багийхан 7 хоногийн турш амбулатори хөтөчийн хэсэгт ажиглалт хийж ажлын байрны зураглал гаргаж, цаг олголтонд тулгамдаж байгаа зарим асуудлуудыг тодруулах,орон нутгийн мэдээллийн хэрэгслээр болон үйлчлүүлэгчдийн дунд нээлттэй ярилцлага зохион байгуулж, БОЭТөв, ЭМГ болон ӨЭМТ-ийн эмч мэргэжилтнүүд хамтарсан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж тулгамдаж байгаа асуудлаа хэлэлцэн эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх журам боловсруулан ажиллаж байна. Мөн байнгын хүлээгдэлтэй байдаг ЭХО, шүд, ЗСК, зүрхний ЭХО, рентген зураг авалтын кабинетуудад эмчийн тоог нэмэгдүүлэх, уртасгасан цагаар ажиллуулах зэрэг арга хэмжээг авснаар тус кабинетуудад хүлээгдэл буурч өдөртөө үзүүлэх боломж бүрдээд байна. Амбулаторийн цаг олголтын нээлттэй 2 утасны дугаарыг өөрчлөн тогтооход хялбар болгон 70582299, 70582277 дугаартай болгон орон нутгийн мэдээллийн хэрэгслээр мэдээлснээр утсаар цаг олгох үйлчилгээ өргөжиж байна. Цахим үйлчилгээг нэвтрүүлэх ажил эхэлж бүх компьютерүүд суурьлагдаад байна. - Үйлчлүүлэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүлээгдэл чирэгдэлгүй үзүүлэх боломж нөхцөлийг ханган хүнд өвчтэй болон өндөр настай хүмүүсийн шинжилгээг гэрээр нь очиж авч үйлчилж байна. Нийт 17 хүнд шинжилгээ хийсэн байна. -ЭМС-ын А/93 тоот тушаалын дагуу ӨЭМТөвөөс 1832 сорьц, СЭМТөвөөс 128 сорьц,Бона Вита лабораторид 198 сроьц тээвэрлээд байна. -ЭМЯ болон ЦССҮТ хамтарч манай эмнэлгийн цусны салбар банк болон лабораторийн хооронд цахим сүлжээ бий болсон./ www.donorinfo.mn./ Ингэснээр лаборатори болон цусны салбар банкны хооронд шинижлгээний хариу цахимаар дамжиж байна. Мөн донорын цуглуулсан цусанд төмөр, уургийн шинжилгээ хийж эхлээд байна. - БОЭТ-ийн хүлээн авах тасгаар үйлчлүүлэгсдийн 6,3% яаралтай тусламжийн хуудас хөтлөгдсөн,ЭМС-ын 450 дугаар тушаалаар батлагдсан СТ-32 маягтын хөтлөлт

		хангалтгүй байдлаас үндэслэн 2017.01.015-.02.15 хүртэл 1 сарын хугацаатай аян зохион байгуулж аяны хүрээнд нийт эмч сувилагч нарт ЭАЯТ,яаралтай тусламжийн хуудас хөтлөлтийн болон ЭМС-ын 375 дугаар тушаал,450 дугаар тушаалыг танилцуулах сургалт хийгдэж аяны хугацаанд яаралтай тусламжийн хуудсанд явцын болон үр дүнгийн үнэлгээ хийгдэж хуудас хөтлөлт 94% болж сайжирсан үр дүнтэй байна.
2.	Дутагдалтай байгаа орон тоог нөхөж төсвийн нөөц бололцоондоо тулгуурлан холбогдох мэргэжлийн боловсон хүчнийг авч ажиллуулах	Эмэгтэйчүүдийн их эмч 1, ариутгагч 1 ,статистикч эмч 1, шүдний эмч 1, эрүүл ахуйч эмч 1,ерөнхий мэргэжлийн эмч 2 авч ажиллуулж байна. Цаашид сэтгэл зүйч гэрээгээр ажиллуулах,яаралтай тусламжийн эмч, өдрийн эх баригч, хүний нөөцийн менежерийн цалингийн санг зохицуулан сонгон шалгаруулалт явуулахаар удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулаад байна. Чойбалсан хотын захирагчийн дэмжлэгээр 1 шүдний эмчийн цалингийн санг шийдвэрлэж өгөхөөр болоод байна.
3.	Дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулж ажиллах	-ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу бүх тасаг нэгжүүдэд хийгдэх дотоод хяналтын хуваарь, төлөвлөгөө боловсруулан батлуулж мөрдөн ажиллаж байна. -Монгол улсын шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2012 оны 06/25 тоот тушаал, БОЭТ-ийн захирлын 2015 оны А/41 тоот тушаалыг үндэслэн БОЭТ-ийн тасаг нэгжүүдийн үйл ажиллагаанд батлагдсан хуваарийн дагуу удирдамж боловсруулан дотоод хяналт хийж байна. Хяналтыг Чанарын алба,Сувилахуйн алба,Халдвар судлаач эмч, Клиник эм зүйч гэсэн бүрэлдэхүүнтэй баг халдварт, хүүхэд, сүрьеэ,доторын тасаг нэгжүүдээр явж гүйцэтгэлээ. Дотоод хяналтаар тушаал шийдвэр,оношилогоо эмчилгээний стандартын хэрэгжилт,тасаг нэгжүүдийн чанарын багийн үйл ажиллагаа,халдвар хяналтын багийн үйл ажиллагаа,сувилахуйн анхан шатны бүртгэл маягтын хөтлөлт, түгээмэл үйлдлийн стандартын хэрэгжилт, хувцаслалт харьцаа хандлага,сувилгааны 5 шатлал, 5С зарчмын хэрэгжилт,эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, зарцуулалт, эмийн зохистой хэрэглээний талаар авч хэрэгжүүлж буй ажлууд,хог хаягдал, гар угаалт, ажлын байрны эмх цэгц, эрүүл ахуй, халдвар хяналтын ажилтны дотоод хяналт,цэвэрлэгээ үйлчилгээ түүний материал,тоног төхөөрөмжийн хангалт, хэрэглээ, засвар үйлчилгээий байдал,үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа,сайн мэдээ, алдаа зөрчилийн бүртгэл мэдээлэл зэрэгт хяналт үнэлгээ хийж илэрсэн зөрчилийн дагуу зөвлөмж өгч санал хүсэлтийг бүртгэн удирдлагын багт танилцуулав. -Цаг товлох үйлчилгээний журмын хэрэгжилтэд хяналт тавих хүлээгдэл чирэгдлийг бууруулах “Хяналтын баг”-ын ажиллах хуваарийг батлан 7 хоног бүр хяналтын баг ажиллаж шаардлагатай зохион байгуулалтыг хийн ажиллаж байна. -Шилэн дансны хуулийн хэрэгжилтыг хангах зорилгоор БОЭТ-ийн захирлын А/86 тоот

		тушаалын дагуу шилэн дансны мэдээллийг байгууллагын веб сайтад хуулийн хугацаанд ил тод байршуулж байгаа байдалд дотоод хяналт хийн ажиллаж байна. -ЗГ-ын нээлттэй утас 11-11 төвд ирсэн иргэний гомдлын дагуу ХСХ-ын баг,ЧА-ны хамтарсан хурлаар хэлэлцэж мэс засал , хүүхдийн тасгийн АШМ хөтлөлтийн байдал, эмийн зохистой хэрэглээ, стандарт удирдамжийн мөрдөлт зэрэгт төлөвлөгөөт бус дотоод хяналт хийж илэрсэн зөрчлийн алдаа зөрчлийн санд бүртгэн, холбогдох тасаг нэгжүүдэд мэдээлж ажилласан. -ЭМС-ын 187 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу гар угаах халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байдал,гарын эрүүл ахуй сахилтыг сайжруулах чиглэлээр хийж буй үйл ажиллагаа,эрүүл мэндийн ажилтны халдвараас сэргийлэх арга хэмжээ зэргийг хяналтын хуудасаар үнэлгээ хийж дүнг удирдлагын багт танилцуулж шаардлагатай зарим арга хэмжээ авч ажиллаа. -“Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөчийн хөтлөлт”-ийг сайжруулах аяны хүрээнд “Жирэмсний хөтөч”-д дотоод хяналт хийж үзэхэд канондсон карт хэрэглэх,нөлөөлөх хүчин зүйлсийг дутуу үнэлсэн,картыг асуумжийн дагуу бүрэн бөглөдөггүй, дараагийн ирэлтийн хугацааг бичдэггүй,зөвлөгөө авсан эхийн гарын үсэг дутуу, ЭХО- дүгнэлтийг картанд тэмдэглэхгүй,жирэмсний явцыг удирдах шийдвэрлэх төлөвлөгөөг гаргаагүй, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг дутуу, үр дүнгүй үзлэг их байдгаас эмч нар бие биенийхээ ачааллыг нэмдэг зэрэг зөрчилүүд илэрсэнээс гадна өртөмтгийн бүлгийн эхчүүдчийн хяналт сайжирсан, хяналтын картны эмх цэгц сайжирсан зэрэг дэвшилттэй сайн талууд байлаа.
4.	Үндсэн үйл ажиллагааны орлого, гадаад ажилчдын эрүүл мэндийн үзлэг шинжилгээний орлогыг бодитой төлөвлөх	-Тасаг нэгж бүрээс оруулдаг орлогыг сүүлийн 3 жилээр судалгаа хийж орлогын төлөвлөгөө боловсруулахад ашиглаж байгаа бөгөөд тасаг нэгжүүдээс шинээр хийгдэх үйлчилгээ, үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлт хийх санал,өртөг зэргийг гаргуулан судалгаа хийж байна. - 2018-2020 оны дунд хугацааны төлөвлөгөө хийгдэж байна. Орлогыг хийгдсэн судалгааны дагуу бодитой төлөвлөх бодлого барьж байна. -Зарим тусламж үйлчилгээний өртөг зардлын тооцоолол хийж бодит байдалд нийцүүлэн үнэ тарифыг нэмэгдүүлсэн. Тухайлбал: Нүдний болорын хагалгаа, дурангийн мэс заслын хагалгаа, лабараторын шинжилгэний үнийн тарифийг нэмэгдүүлсэн. Нүдний дурангийн мэс засал болон лабораторийн шинжилгээний бодит өртгийн тооцоо хийж удирдлагын зөвлөлийн хуралаар хэлэлцүүлж ,клиник биохимийн лабораторийн шинжилгээний үнийн жагсаалтыг БОЭТ-ийн захирлын А/30 дугаар тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна. -Одоогоор гадаад ажиллагсдын тоо тодорхойгүй тул бодитой төлөвлөх боломжгүй

		байна.
5.	ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэвших	2017 онд байгууллагад хэрэгцээтэй бараа материалын худалдан авалтыг ТБОНАБАҮХАТХуулын дагуу зохион байгуулж худалдан авалтыг хийж хэвшсэн. Дараах тендрүүдийг зохион байгуулж ажиллалаа. Үүнд: -Эм, эмнэлгийн хэрэгслийн тендер: ЭМГ-ын даргын 2016 оны А/39 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулж, худалдан авах ажиллагааны журмын дагуу нээлттэй тендерийг зохион байгуулсан. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд АЗДТГ-аас 1, ЭМГ-аас 2, БОЭТ-өөс 4, ТББ-с 1 төлөөлөл оролцож, 26 багц бүхий 904,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зарлагдан , уг тендерт 20 байгууллага оролцсон бөгөөд 13 эм ханган нийлүүлэх байгууллага шалгарч 923,4 сая төгрөгийн гэрээ байгуулсан. -Шатахуун, тослох материалын тендер: БОЭТ-ийн захирлын 2017 оны А/17 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан, тендер шалгаруулалтын онцгой журмын дагуу харьцуулалтын аргаар тендерийг зохион байгуулсан. Үнийн санал ирүүлэх урилгыг орон нутгийн шатахуун борлуулдаг 4 компанид хүргүүлсэнээс НИК ХХК, Сод монгол ХХК, Тэс петролиум ХХК, Магнай трейд ХХК-иуд тендерт оролцож,ажлын хэсэг үнэлгээ, харьцуулалтыг хийж “Сод Монгол” ХХК-ыг шаардлагад нийцсэн хамгийн сайн тендер ирүүлсэн гэж үзээд 49,6 сая төгрөгийн шатахуун нийлүүлэх гэрээ байгуулсан. -Хүнсний материалын тендер: 7 багц болгон зарласан бөгөөд 8 компани тендэрт оролцсоноос 6 компанитай гэрээ хийсэн. / Ольхон, Дорнод дээж, Дорнын алтан тал, Санбэйс , Дорнод гурил, Авьяа, Сүүн-Орд / Нээлттэй тендэр шалгаруулалтын журамын дагуу зохион байгуулж төсөвт өртөг 200,9 сая бөгөөд 195,0 сая төгрөгийн гэрээ байгуулсан. -Аж ахуй хангамж болон цэвэрлэгээний материалын тендер: БОЭТ-ийн захирлын 2017 оны А/17 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан. / Эхний тендер амжилтгүй болсон / . Үнийн санал ирүүлэх урилгыг орон нутгийн бөөний болон тухайн бараа бүтээгдэхүүн худалдаалдаг 6 компанид хүргүүлсэнээс 4 ХХК үнийн санал ирүүлж, ажлын хэсэг үнэлгээ хийж “Авьяа” ХХК-ыг шаардлагад нийцсэн хамгийн сайн тендер ирүүлсэн гэж үзээд 33,6 сая төгрөгийн материал нийлүүлэх гэрээ байгуулсан. -Гэрээт харуул хамгаалалтын сонгон шалгаруулалт: БОЭТ-ийн захирлын 2017 оны А/20 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын

		хэсэг байгуулан, орон нутагт харуул хамгаалалтын үйл ажиллагаа явуулдаг “Цагаан шонхор” ХХК, “Түшиг хамгаалалт” ХХК – иудад урилга хүргүүлсэн бөгөөд тус 2 байгууллага оролцсон. Ажлын хэсэг харьцуулалт, үнэлгээ хийж “Түшиг хамгаалалт” ХХК-ыг шаардлагад нийцсэн хамгийн сайн тендер ирүүлсэн гэж үзээд 28,8 сая төгрөгийн үйлчилгээ буюу харуул хамгаалатын гэрээ байгуулсан.
6.	Түргэн тусламжийн автомашиныг зориулалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	-Одоо ашиглагдаж байгаа ЯТТ-ын автомашинуудад механикаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж шаардлагатай байгаа сэлбэг хэрэгслийн судалгаа хийн засварлах шаардлагатай автомашинуудыг засварласан. -Мөн ЭМЯ – ЯТТ-ын парк шинэчлэлтийн саналыг хүргүүлсэний дагуу ЯТТ-ын 28,0 сая төгрөгийн өртөг бүхий УАЗ пурган маркын автомашинаар хангасан. Бусад шаардлагатай сэлбэг хэрэгсэл болон зөөврийн хүчилтөрөгчийн баллон, пульсокиметр зэрэгт нийт 1931340 төгрөг зарцуулаад байна.
7.	Тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх	-Хандив тусламжаар: Адуун чулууны уурхайтай хамтын ажиллагаатай ажиллаж мэс заслын тасагт 3 сая төгрөгийн тавилга хэрэгсэлээр хангасан. - 2017 оноос эхлэн Сетунари ХХК-ний Roche –ийн 3 төрлийн анализатори суурьлагдаад байна.Үүнд: Биохимийн бүрэн автомат С-311 анализатори нь нэг дор 17 үзүүлэлтээр өөх тос, холестрин,триглицрид,төмөр, сахар,электролитууд, элэг, нойр булчирхай, бөөрний үйл ажиллагааны шинжилгээ хийх боломжтой. Иммунологийн Е-411 бүрэн автомат анализатори нь В,С вирусын шинжилгээ, хавдарын маркерууд,бамбай булчирхайн гормон,бэлгийн даавар ,TORCH халдварын шинжилгээ, IgM, IgG, бруцеллёз,витамин Д шинжилгээ хийх боломжтой боллоо. Гематологийн Pentra EX -60 гематологийн анализатори нь 1цагт 60 хүний шинжилгээг 23 үзүүлэлтээр хийх хүчин чадалтай. Клиник биохимийн лабораторид В ,С вирус илрүүлэх шинжилгээг элиза анализаториор хийж байна. Аймгийн төсвийн санхүүжилтээр нийлүүлэгдсэн электорлитийн анализатори нь 5 үзүүлэлтээр / Ca, K,Na,Cl ,Ph/ цус болон шээсэнд шинжилгээ хийх боломжтой болсоноор оношилгооны нэр төрөл олширч, эмч ажилагсдын болон үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нэмэгдэж байна. -Нэмэлт үйлчилгээний орлогоос: Мэс заслын тасагт хагалгааны багаж тавих ширээ 2ш- 840,0 мян Мэс заслын тасгийн толижилтонд TY-500, төг

		Гэмтлийн хагалгааны дунд мөчний суурь багаж-иж бүрдэл -2,0 сая Дуслын шахуурга, Пульс оксиметр-3950,0 төг Нүдний хагалгааны багаж шинэчлэл -1358,5 мян -ОНХСангийн хөрөнгө оруулалтаар : Хүүхдийн шүдний бор машин 2ш Хүүхдийн тасагт нэн шаардлагатай тоног төхөөрөмж 15,0 сая төгрөг Шүдний рентгэн аппарат Дерматомын аппарат Суурин искра аппарат Хүүхдийн шарлалт хэмжигч аппарат зэргийг нийлүүлэд байна. Мөн ЭМС-аас дараах тоног төхөөрөмжийн батламж гардуулаад байна. Үүнд: Компьютерт томографийн аппарат 16 зүслэгтэй Хүчилтөрөгийн бэсрэг үйлдвэр-1 Ходоодны дурангийн иж бүрдэл-1 Ургийн монитор-1 Центрифуг-4 Сорьцын хөргөгч -4 Хяналтын монитор-3 Мэс заслын гэрэл-1 Нярайн инкубатор-1 Нярайн дулаацуулах ширээ-1 Нярайн шарлагын аппарат-1 Унтуулгын аппарат-1 Амьсгалын аппарат-1 B,C вирус тодорхойлогч /Gene-expert/-1 Өвчтөний ор-20
8.	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харьцаа хандлагыг сайжруулах	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороог ишнэчлэн зохион байгуулахаар төлөвлөөд байна.

Гүйцэтгэлийн тайлан бичсэн: Чанарын албаны дарга Д.Ганхүрэл.